



МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХОРООНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХОРООНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН ТООН МЭДЭЭЛЛЭЭР



Өдөрлог,
арга хэмжээ

2

Удирдах
зовлолийн
хурал

3

Спорт, аялал
арга хэмжээ

3

Хэлэлцүүлэг

6

Контент

3

Оюутны
эрдэм
шинжилгээний
хурал

1

Гадаад
харилцаа

2

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХОРООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ХУРАЛ, ТАНИЛЦУУЛГА

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХОРООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

Хорооны тэргүүн:

1. Г. Даваадорж - Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны Ерөнхий шүүгч

Хорооны гишүүд:

2. Ч.Отгонбаатар - Өмгөөлөгч

3. Д.Түвшинтамир - Өмгөөлөгч

3. Т.Наранцогт - Өмгөөлөгч

4. Б.Мөнхбат - Өмгөөлөгч

5. С.Цацралтуяа - Өмгөөлөгч

6. О.Вандандорж - Өмгөөлөгч

7. М.Ванчигмаа - Өмгөөлөгч

8. Г.Давааням - Өмгөөлөгч

9. Б.Зол-Ундрах - Бусад хуульч

Иргэний эрх зүйн хорооны удирдах зөвлөлийн хурал:

- 2024 оны 01 дүгээр сарын 16

- 2024 оны 04 дугаар сарын 05

- 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрүүдэд тус тус хуралдсан.



МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНД УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ОРОЛЦОО

Хорооны тэргүүн:

1. Г. Даваадорж - Цахимжилт ба барын холбоо, Шүүхийн цахимжилт ба тулгамдсан асуудлууд сэдэвт хэлэлцүүлгүүдийг биечлэн зохион байгуулж, бэлтгэл ажлыг хангуулан ажилласан.

Хорооны гишүүд:

2. Ч.Отгонбаатар - МХХ-ноос зохион байгуулдаг томоохон арга хэмжээнүүдийн ажлын хэсэгт хороогоо төлөөлөн орж ажилласан. Жишээ нь: Хуульчдын форум, Моктриал шүүхийн мэтгэлцээн гэх мэт.

3. Д.Түвшинтамир - Хорооноос зохион байгуулдаг үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог.

3. Т.Наранцогт - Зөвлөлийн хурал, хорооны хэлэлцүүлэгүүдэд идэвхтэй оролцдог.

4. Б.Мөнхбат - Өмгөөлөгч - Хорооноос зохион байгуулдаг ажилд идэвхтэй оролцож, зарим санхүүжилтыг дэмжин оролцдог.

5. С.Цацралтуяа - Өмгөөлөгч - Холбооноос зохион байгуулдаг спортын арга хэмжээнд багаа бүрдүүлэн идэвхитэй оролцсон.

6. О.Вандандорж - Өмгөөлөгч - Холбооноос зохион байгуулдаг спортын арга хэмжээнд багаа бүрдүүлэн идэвхитэй оролцсон.

7. М.Ванчигмаа - Өмгөөлөгч, МХХ-ны сургагч багш бөгөөд 2024 онд хэд хэдэн кредит цагийн хичээлийг заасан. Гэр бүлийн тухай хууль: Монгол Улс ба БНСУ-ын туршлага хэлэлцүүлэгт илтгэл хэлэлцүүлж, зохион байгуулсан.

8. Г.Давааням - Өмгөөлөгч, МХХ-ны сургагч багш бөгөөд 2024 онд хэд хэдэн кредит цагийн хичээлийг заасан. Мөн Компаний тухай хууль хэлэлцүүлэг, Хуульчдын форумд илтгэл хэлэлцүүлсэн.

9.Б.Зол-Ундрах - Хорооноос зохион байгуулдаг үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог.

1. ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ХҮРЭЭНД:

1.1. “Хувийн эрх зүйн хөгжилд хуульчдын оролцоо” уулзалт ярилцлага

Монголын Хуульчдын холбооны Иргэний эрх зүйн хорооноос 2024 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр “Хувийн эрх зүйн хөгжилд Хуульчдын оролцоо” сэдэвт чөлөөт уулзалт ярилцлагыг их, дээд сургуулийн багш, судлаачдын дунд зохион байгуулсан. Уулзалт ярилцлагад Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч, доктор П.Одгэрэл оролцож Монголын Хуульчдын Холбооны үйл ажиллагаа болон 2024 оны үйл ажиллагааны зорилтын талаар мэдээлэл хийсэн.



Уулзалт, ярилцлага нь хувийн эрх зүйн хөгжлийн чиг хандлага, хууль зүйн дээд боловсролыг олгох тогтолцоонд тулгамдаж буй асуудлууд, Монголын Хуульчдын Холбоо, Иргэний эрх зүйн хорооны үйл ажиллагаанд хувийн эрх зүйн эрдэмтэн, судлаачид хамтран ажиллах нөхцөл боломжийн талаар өөрсдийн санал бодлоо солилцсон бөгөөд тус уулзалт, ярилцлагад хууль зүйн дээд боловсрол олгох 9-н их сургуулийн хувийн эрх зүйн багш, судлаачид оролцсон бөгөөд эрдэмтэн, судлаач нар хувийн эрх зүйн эрдэмтэн, судлаачдын хамтын ажиллагаа чухал байгааг онцолсон.

1.2. Арилжааны хууль сэдэвт хэлэлцүүлэг

Монголын Хуульчдын холбооны Иргэний эрх зүйн хорооноос 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдөр “Арилжааны хууль” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хууль зүй, дотоод хэргийн яам Арилжааны хуулийн төслийг боловсруулсан бөгөөд Арилжааны хуулийн төслөөс “арилжааны төлөөлөл” болон “арилжааны нэр”-ний зохицуулалтыг тухайлан хэлэлцлээ. Хэлэлцүүлэг нь илтгэл болон хэлэлцүүлэг гэсэн хоёр хэсэгтэй зохион байгуулагдсан.



Хэлэлцүүлгийн илтгэлийн хэсэгт “Арилжааны хуулийн зохицуулалтын хүрээ: арилжааны нэр, төлөөллийн тусгайлсан зохицуулалт” сэдвээр ХЗДХЯ-ны Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Н.Жамъянхүү (LL.M), “Арилжааны төлөөллийн ойлголт, түүний зохицуулалт” сэдвээр МУИС-ийн ХЗС-ийн багш, Иргэний эрх зүйн хорооны Удирдах зөвлөлийн гишүүн, хууль зүйн доктор Г.Давааням (LL.D), “Арилжааны нэрийн ойлголт, түүний зохицуулалт” сэдвээр МУИС-ийн ХЗС-ийн багш Н.Норовсамбуу (LL.M) нар тус тус илтгэл хэлэлцүүлсэн.

Хэлэлцүүлгийн хэсэгт панелистаар УДШ-ийн шүүгч, хууль зүйн доктор Н.Баярмаа (LL.D), ХЗДХЯ-ны Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Н.Жамъянхүү (LL.M), ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор М.Түвшинжаргал (Ph.D), МУИС-ийн ХЗС-ийн багш, Иргэний эрх зүйн хорооны Удирдах зөвлөлийн гишүүн, хууль зүйн доктор Г.Давааням (LL.D) нар оролцож, оролцогчдын сонирхсон асуудлаар судлаачийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, сонирхолтой хэлэлцүүлгийг өрнүүлсэн.

Хэлэлцүүлэгт оролцогчид энэхүү хэлэлцүүлэг нь цаг үеэ олсон, ач холбогдол бүхий сэдвийг сонгосон талаар онцлон тэмдэглэж, цаашид “Арилжааны эрх зүй”-н хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн зохион байгуулах санал хүсэлт илэрхийлсэн.

1.3. Гэр бүлийн тухай хууль: Монгол Улс ба БНСУ-ын туршлага хэлэлцүүлэг

Монголын Хуульчдын холбооны Иргэний эрх зүйн хорооноос 2024 оны 03 дугаар сарын 21-ны өдөр “Гэр бүлийн тухай хууль: Монгол Улс ба БНСУ-ын туршлага” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Тус хэлэлцүүлгийг нээж Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл үг хэлсэн. Тус хэлэлцүүлэгт:



- “Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга” сэдвээр Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоо;

- “БНСУ-ын Гэр бүлийн эрх зүйн харилцаан дахь гэм хорын ойлголт, шүүхийн практик” сэдвээр БНСУ-ын гэр бүлийн эрх зүй судлалын холбооны ерөнхийлөгч, хууль зүйн доктор, профессор Чон Гён Гин;

- “Гэр бүлийн эрх зүйн харилцаан дахь эдийн бус гэм хорын ойлголт, шүүхийн практик” сэдвээр ОУУБИС-ын Монгол-Солонгосын эрх зүйн судлалын холбооны ерөнхийлөгч, хууль зүйн доктор, профессор О.Амарсанаа;

- “Гэрлэлийн гэрээ, практикт тулгамдаж буй зарим асуудал” сэдвээр Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Д.Нямбазар, ДХИС-ийн ЭЗНУС-ийн ХЭЗТ-ийн ахлах багш, доктор, Иргэний эрх зүйн хорооны удирдах зөвлөлийн гишүүн М.Ванчигмаа нар тус тус илтгэл хэлэлцүүлээ.

Тус хэлэлцүүлгийн хэлэлцүүлэгчээр:

- Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын хувийн эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч М.Цолмон;

- ДХИС-ийн ЭЗНУС-ийн ХЭЗТ-ийн ахлах багш, доктор, Иргэний эрх зүйн хорооны удирдах зөвлөлийн гишүүн М.Ванчигмаа;

- УУБИС-ийн Монгол-Солонгосын эрх зүйн хүрээлэнгийн захирал, хууль зүйн доктор О.Амарсанаа нар хэлэлцүүлээ.

Хэлэлцүүлгийн чиглүүлэгчээр:

- Иргэний эрх зүйн хорооны удирдах зөвлөлийн гишүүн хуульч, өмгөөлөгч А.Батбаатар хэлэлцүүлээ.



**ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ:
МОНГОЛ УЛС БА БНСУ-ЫН ТУРШЛАГА
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

<p>О. АМАРСАНАА ОУУБИС-ийн Монгол-Солонгосын эрх зүйн хүрээлэнгийн захирал, хууль зүйн доктор</p>	<p>Б. СОЛОНГО Хууль зүй, дотоод хэргийн яамны хууль зүйн бодлогын газрын хувийн эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч</p>	<p>ЧОН ГЁН ГИН БНСУ-ын Гэр бүлийн эрх зүйн харилцаан дахь гэм хорын ойлголт, шүүхийн практик сэдвээр</p>	<p>Д. НЯМБАЗАР Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч</p>	<p>М. ВАНЧИГМАА Иргэний эрх зүйн хорооны удирдах зөвлөлийн гишүүн</p>
------------------------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------

2024 оны 3 дугаар сарын 21-ний өдөр/н Өлзийт суурин 09:00 цагт болно. Хуульчдын хэлбэл "Хуульчдын төлөхө"

1.4. “Цахимжилт ба барын холбоо” хэлэлцүүлэг

Монголын Хуульчдын холбоо, АНУ-ын Монгол Улс дахь Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яам, Монголын Өмгөөлөгчдийн холбоо хамтран “Цахимжилт ба барын холбоо”, “Дижитал шилжилт ба өмгөөлөгч” сэдэвт хэлэлцүүлгийг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгийг нээж МХХ-ны Ерөнхийлөгч П.Одгэрэл, Монголын Өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч Л.Данзанноров нар үг хэлсэн.

“Монголын Хуульчдын холбооны цахимжилтын өнөөгийг нөхцөл байдал, тулгарч буй асуудлууд” сэдвээр МХХ-ны Тамгын газрын дарга Ш.Жолбарс, “АНУ-ын Бар-ын холбоо нь АНУ-ын шүүхийн цахимжилтад хэрхэн нөлөөлж, идэвхтэй оролцсон талаарх туршлага танилцуулга” сэдвээр АНУ-ын Аризона мужийн Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Роберт М.Брютинел, АНУ-ын Аризона мужийн Дээд шүүхийн захиргааны албаны захирал Дэйв Байерс нар танилцуулга хийсэн.

Тус хэлэлцүүлгийн чиглүүлэгчээр МХХ-ны Зөвлөлийн гишүүн Ч.Отгонбаатар хийсэн.

Монгол Улсын шүүх цахимжилтад шилжихэд тулгамдаж буй асуудал, хүндрэл, хүрэх замын талаар хэлэлцэж, АНУ-ын туршлагаас судалсан.



1.5. Шүүхийн цахимжилт ба тулгамдсан асуудал” хэлэлцүүлэг

Монголын Хуульчдын холбоо, АНУ-ын Монгол Улс дахь Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яам хамтран хэрэгжүүлж буй “US speaker” хөтөлбөрийн хүрээнд “Шүүхийн цахимжилт ба тулгамдсан асуудал” хэлэлцүүлгийг 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр зохион байгууллаа.

Тус хэлэлцүүлгийг нээлтийг нээж Монголын хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл, АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Ричард Буанган, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нар үг хэллээ.

“Цахимжилт ба Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдвээр Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Энхжаргал, “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа ба цахимжилт” сэдвээр Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.Батбаатар, “Эрүүгийн шүүхийн цахимжилт, тулгамдсан асуудал” сэдвээр Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.Галбадар, Аризона мужийн “Шүүхийн цахимжилт” сэдвээр АНУ-ын Аризона мужийн Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Роберт М.Брютинел нар илтгэл хэлэлцүүлсэн.

Тус хэлэлцүүлгийн чиглүүлэгчээр Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны Ерөнхий шүүгч Г.Даваадорж,

Панелитаар Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүн Р.Онончимэг, АНУ-ын Аризона мужийн Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Роберт М.Брютинел, Аризона мужийн Дээд шүүхийн захиргааны албаны захирал Лэйв Байерс, “Аствишн” ХХН-ийн Систем архитектур, загварчилал хариуцсан захирал Т.Мөнх-Очир нар тус тус оролцлоо.



1.6.Хуульчдын форум 2024-д Иргэний эрх зүйн хорооны салбар хуралдааныг зохион байгуулж ажилласан.

“Иргэний эрх зүй дэх асуудал, шинэчлэл” салбар хэлэлцүүлгийн модератороор “Анд глобал”, “Ондо холдинг”-ийн ТУЗ-ийн дарга Ч.АНАР, илтгэгч, панелистаар Монголын Хуульчдын холбооны Иргэний эрх зүйн хорооны УЗ-ийн гишүүн, хуульч, Хууль зүйн ухааны доктор Г.Давааням, панелистаар УДШ-ийн шүүгч, Хууль зүйн ухааны доктор Н.Баярмаа, МУИС-ийн ХЗС-ийн захирал, Хууль зүйн ухааны доктор Б.Амарсанаа, Хуульч, арбитрч, Хууль зүйн ухааны доктор Т.Мэндсайхан, “Кийстөүн Легал” ХХН-ийн захирал, хуульч, өмгөөлөгч А.Мандуул оролцсон бол “Эрүүгийн эрх зүй дэх асуудал, шинэчлэл” салбар хэлэлцүүлгийн модератороор “Хар хайрцаг” нэвтрүүлгийн хөтлөгч Г.Гантүшиг, илтгэгч, панелистаар МУИС-ийн ХЗС-ийн багш, судлаач, хууль зүйн ухааны доктор Т.Золбоо, панелистаар ХЭҮК-ийн гишүүн, Хууль зүйн ухааны доктор Б.Энхболд, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л. Галбадар, Хуульчдын холбооны Зөвлөлийн гишүүн, хуульч Б.Баяраа, Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульч, өмгөөлөгч Д.Одонтунгалаг нар оролцож өөрсдийн байр суурь, саналыг илэрхийлсэн юм. Удирдах зөвлөлийн гишүүн Ч.Отгонбаатар зохион байгуулалтад оролцож ажилласан.



2.ГАДААД ХАРИЛЦАА

2.1.Иргэний эрх зүйн хорооны тэргүүн Г.Даваадорж АНУ-ын Аризона мужийн шүүхийн цахимжилттай танилцлаа.

Монголын Хуульчдын холбоо нь Иргэний эрх зүйн хорооны санаачлагаар “Шүүх эрх мэдлийн байгууллагуудын Цахимжилт” сэдвээр АНУ-ын ЭСЯ-тай хамтран 2024 оны гуравдугаар сард “US speaker” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн. “US speaker” хөтөлбөр нь АНУ-ын Төрийн департамент болон АНУ-ын ЭСЯ хамтран стратегийн чухал сэдвүүдээр АНУ-ын мэргэжилтнүүдийг гадаад улсын мэргэжилтнүүдтэй холбох, харилцан туршлага солилцох боломжийг олгодог билээ.

Хөтөлбөрийн хүрээнд АНУ-ын Аризона мужийн Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Роберт Брутинел, мужийн Дээд шүүхийн Захиргааны албаны захирал Дэйв Байерс нар хүрэлцэн ирж, Монголын Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо, Шүүхийн Ерөнхий зөвлөл, Улсын Дээд шүүх, Давж заалдах шатны шүүх, Шүүхийн Сахилгын хороо, Улсын Ерөнхий прокурорын газрын сургалт, судалгааны хүрээлэн зэрэгт зочилж, УИХ-ын Дэд дарга Л.Мөнхбаатар, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар нартай уулзсан юм. Тэд манай улсын шүүх эрх мэдлийн байгууллагуудын цахимжилттай танилцаж, Аризона мужийн шүүхийн цахимжилтын талаар харилцан туршлага солилцож, үр дүнтэй уулзалт, хэлэлцүүлгүүдэд оролцсон. Аризона бол АНУ-д шүүхийн цахимжилтыг хамгийн амжилттай хэрэгжүүлж байгаа муж юм. Тэгвэл “Шүүх эрх мэдлийн байгууллагуудын Цахимжилт” сэдэвт “US speaker” хөтөлбөрийг санаачлан зохион байгуулагч, Иргэний эрх зүйн хорооны тэргүүн, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Г.Даваадорж 2024 оны зургадугаар сарын 27-ноос долдугаар сарын 1-ний өдрүүдэд АНУ-ын Аризона мужийн шүүхийн цахимжилттай танилцаж, харилцан туршлага солилцлоо.

Тэрбээр Аризона мужийн Дээд шүүхээр зочилж, долдугаар сарын 1-ний өдөр шинээр сонгогдсон Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Анн Скотт Тиммер, шүүгч Роберт Брутинел болон Захиргааны албаны захирал Дэйв Байерс нартай уулзаж, шүүхийн цахимжилтын талаар харилцан туршлага солилцов. Мөн Аризона мужийн Flagstaff, Phoenix хотын анхан болон давж заалдах шатны шүүхээр зочилж, E-Filing, E-Bench, AJACS системүүдийг үзэж танилцсан бөгөөд Аризона мужийн зарим шүүх Хиймэл оюун ухааныг шүүхийн захиргааны үйл ажиллагаа, статистик мэдээ болон хуульч, өмгөөлөгч, иргэдэд зориулан ашиглаж байгаа туршлагыг танилцуулжээ. Түүнчлэн Аризона мужийн 130 гаруй шүүхийн цахим системийг хариуцдаг нэгдсэн Дата төвтэй танилцсан байна.



2.2. "Хиймэл оюун ухаан ба шүүх эрх мэдэл" сэдэвт олон улсын хуралд Иргэний эрх зүйн хорооны тэргүүн Г.Даваадорж оролцлоо.

Олон Улсын Шүүхийн захиргааны холбооны ээлжит хурал Сингапур Улсад 2024 оны арваннэгдүгээр сарын 11-14-ний өдрүүдэд зохион байгуулагдлаа.

Хуралд Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн А.Насандэлгэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, Монголын Хуульчдын холбооны Иргэний эрх зүйн хорооны тэргүүн Г.Даваадорж, АНУ-ын Элчин сайдын яамны ажилтан М.Номинцэцэг нар оролцлоо.

Хурлыг Олон Улсын Шүүхийн захиргааны холбооны Ерөнхийлөгч Луис Мариа Палма, Сингапур Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Сундареш Мэнон нар нээж үг хэлсэн. Тэрбээр цахимжилт нь шүүх эрх мэдлийн хөгжилд, тэр дундаа шүүхэд мэдүүлэх, шүүхийн үйл ажиллагааг улам бүр нээлттэй, ил тод болгох, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтойг онцлон дурдсан юм.

Олон Улсын Шүүхийн захиргааны холбооны 20 жилийн ойг тохиолдуулан уг хуралд олон орны шүүгч, шүүхийн захиргааны ажилчид оролцон шүүхийн үйлчилгээнд технологийн дэвшлийг нэвтрүүлэх, хиймэл оюун ухааныг хэрхэн ашиглах асуудлаар харилцан туршлага солилцож, мөн "Шүүхийн захиргааны болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хиймэл оюун ухааныг ашиглах", "Хиймэл оюун ухаан ба Шударга ёсны хүртээмж, технологийн хөгжлийг уялдуулах нь", "Хиймэл оюун ухаантай холбоотой сорилт ба эрсдэл", "Худал мэдээлэл, итгэл, харилцаа холбоо, үнэн зөв байдал" гэх мэт чухал ач холбогдолтой илтгэлүүдийг хэлэлцүүлсэн.



3. ИЛТГЭЛИЙН УРАЛДААН, ӨДӨРЛӨГ, ВИДЕО КОНТЕНТ БҮТЭЭЛ

3.1. “Үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, чиг хандлага” сэдэвт илтгэлийн уралдаан

Монголын Хуульчдын Холбооны Иргэний эрх зүйн хорооноос уламжлал болгон хууль зүйн их, дээд сургуулийн оюутнуудын дунд зохион байгуулдаг эрдэм шинжилгээний илтгэлийн уралдааныг “Үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, чиг хандлага” сэдвийн хүрээнд зохион байгууллаа.

Уралдаанд ирүүлсэн илтгэлүүдээс Иргэний эрх зүйн хорооны Удирдах зөвлөлөөс сонгогдсон хуульч нар дараагийн шатанд оролцох илтгэлүүдийг урьдчилан шалгаруулсан бөгөөд хоёрдугаар шатанд 12 оюутны 9 илтгэл шалгарсан. Эдгээр илтгэлүүдийг 2024 оны дөрөвдүгээр сарын 30-ны өдөр хэлэлцүүлж, шилдгүүдийг тодруулсан.

-Нэгдүгээр байранд: “Нээлттэй арилжаалах үнэт цаасыг бүртгэлээс хасах (Delisting) эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудал” сэдвээр Санхүү эдийн засгийн их сургуулийн оюутан Ж.Энхмаа;

-Хоёрдугаар байранд: “Үнэт цаасны зах зээлийн дотоод мэдээлэл арилжаанд оролцох, хохирол тооцох эрх зүйн судалгаа” сэдвээр Санхүү эдийн засгийн их сургуулийн оюутан А.Азжаргал, Ц.Баянбат;

-Гуравдугаар байранд: “Үнэт цаасны зах зээлд индексжүүлсэн хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох хэрэгцээ, шаардлага, давуу тал” сэдвээр МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан Л.Энхсайхан нарын илтгэл тус тус шалгарлаа.

Оюутны эрдэм шинжилгээний илтгэлийн уралдааныг **Өмгөөллийн Легал гайд** хуулийн фирм 2 000 000 төгрөгийн үнэ бүхийн зүйлээн ивээн тэтгэж оролцсон:



3.2. “Шүүхийн цахимжилт ба хавтаст хэрэг”

Иргэний хэргийн шүүхийн шүүгчдийн мэргэшүүлэх сургалтын хүрээнд Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Г.Даваадоржийн бэлтгэсэн видео контент бүтээлээ.



3.3. Хуульч мазаалай өдөрлөгийн 2 контент бүтээсэн

Хуульч Мазаайла өдөрлийг үеэр:

- Шүүхийн танилцуулга болон
- Ном уншихыг уриалсан 2 видео контент бүтээж МХХ-ны холбооны болон хорооны цахим хуудаст байршуулсан.



3.2.Архангай аймагт “Хуульч Мазаалай” өдөрлөг зохион байгууллаа.

Монголын Хуульчдын холбооны Иргэний эрх зүйн хороо Өмгөөллийн “Легал гайд” хуулийн фирмтэй хамтран 2024 оны 12 дугаар сарын 2-ны өдөр Архангай аймагт “Хуульч Мазайлай өдөрлөг зохион байгуулав. Энэхүү өдөрлөгөөр МХХ-ны Иргэний эрх зүйн хорооны УЗ-н гишүүн, Өмгөөллийн Легал гайд хуулийн фирмийн Гүйцэтгэх захирал Ч.Отгонбаатар, МХХ-ны гишүүн, Өмгөөллийн Легал гайд хуулийн фирмийн хуульч Н.Баясгалан нар иргэдэд хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өглөө. Мөн жижиг дунд бизнес эрхлэгчид болон банкны салбарын ажилтан, албан хаагч нарт “Гэрээ байгуулах арга зүй” сэдвээр МХХ-ны гишүүн, Өмгөөллийн Легал гайд хуулийн фирмийн партнер хуульч Э.Эрдэнэхишиг, “Зөрчил шийдвэрлэх ажиллагааны оролцогчид өгөх хууль зүйн мэдээлэл, зөвлөгөө” сэдвээр МХХ-ны гишүүн, Өмгөөллийн Легал гайд хуулийн фирмийн хуульч Т.Мөнх-Очир сургалт хийлээ. МХХ-ны гишүүн, Өмгөөллийн Легал гайд хуулийн фирмийн хуульч Г.Халиун, Өмгөөллийн Легал гайд хуулийн фирмийн хуульчийн туслах Б.Өнөрзаяа, МУИС-н ХЗС-н 5 дугаар түвшний оюутан, дадлагажигч Б.Солонго нар Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 10 дугаар ангийн сурагчдад “Хүүхдийн хөдөлмөрийн харилцаа” сэдвээр сургалт орж, сурагчдын сонирхсон асуултад хариулсан.

Иргэний эрх зүйн хорооны төлөөлөл болон Өмгөөллийн Легал гайд хуулийн фирмийн хамт олон Архангай аймгийн хуульчдын төлөөлөлтэй чөлөөт уулзалтыг зохион байгуулж, Хуульчдын холбоо болон Иргэний эрх зүйн хорооны үйл ажиллагааны талаар ярилцлага хийсэн. Архангай аймаг дахь салбан зохицуулагчаас шүүхийн захиргааны хуульчдын багц цагийн сургалтын асуудлыг хөндөж, Холбоо болон хорооны үйл ажиллагаанд орон нутгийн хуульчдын идэвх, оролцоог дэмжихийг хүссэн. “Хуульч мазаалай” өдөрлөг амжилттай зохион байгуулагдлаа.



4.ТЭМЦЭЭН, АЛХАЛТ АРГА ХЭМЖЭЭ

4.1. “ХУУЛЬЧДЫН ШИЛЖИН ЯВАХ ЦОМ” ТЭМЦЭЭНД ОРОЛЦОЖ 3-Р БАЙР ЭЗЛЭВ.

Монголын Хуульчдын холбооноос жил бүр зохион байгуулдаг “Хуульчдын шилжин явах цом”-ын төлөөх спортын тэмцээн 2024 оны тавдугаар сарын 23-26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан бөгөөд Иргэний эрх зүйн хороо тус тэмцээний бүх төрөлд багаараа идэвхтэй оролцож Г.Даваадорж тэргүүнтэй Иргэний эрх зүйн хорооны баг багийн дүнгээр 3-р байранд шалгарсан. Үүнд:

Биллиард

Эрэгтэй

1-р байр: Иргэний эрх зүйн хороо-Д.Хаш-Эрдэнэ

Боулинг

Багаараа 1-р байр: Иргэний эрх зүйн хороо – Ц.Батзаяа ахлагчтай баг

Волейбол

Эмэгтэй

2-р байр: Иргэний эрх зүйн хороо – Б.Соёлмаа ахлагчтай

Сагсан бөмбөг

Эмэгтэй

3-р байр: Иргэний эрх зүйн хороо-С.Цацралтуяа ахлагчтай

Шилдэг тоглогч:

Боулинг

эрэгтэй: Иргэний эрх зүйн хорооны З.Түвшинжаргал

Багийн дүнгээр 3-р байр: Г.Даваадорж тэргүүнтэй Иргэний эрх зүйн хорооны баг тус тус шалгарлаа.



4.2. СПОРТ, ЯВГАН АЯЛЛЫН ТЭМЦЭЭНД АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО.

Хуульчдын эрүүл мэнд, бие бялдрыг чийрэгжүүлэх, тэдэнд амьдралын зөв дадал, хэвшил олгох, хоорондоо танилцаж туршлага солилцох, байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалах зорилгоор энэхүү аяллыг Монголын Хуульчдын холбооноос санаачилж, хоёр дахь жилдээ зохион байгуулсан бөгөөд тус спорт явган аяллын тэмцээн Улаанбаатар-Урган наран хороолол-Баянзүрх хайрхан-Хар усан тохой гэсэн маршрутаар авто машинаар 15 км, явган алхалтаар 10 км орчимд явагдсан. Тус тэмцээнд Монголын Хуульчдын холбооны Иргэний эрх зүйн хорооны баг тамирчид идэвхтэй оролцсон.



4.3. ШАТРЫН ТЭМЦЭЭНД ОРОЛЦОВ.

Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн нэрэмжит хуульчдын аварга шалгаруулах шатрын тэмцээнийг 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр гишүүн хуульчдынхаа дунд зохион байгууллаа. Спортыг түгээн дэлгэрүүлэх, ур чадварыг хөгжүүлэх, туршлага солилцох зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг тус тэмцээнд Монголын Хуульчдын холбооны 11 хорооны 33 тамирчин оюун ухаан, ур чадвараа сорин өрсөлдсөн бөгөөд Иргэний эрх зүйн хорооноос Түмэнбаярын Сайнбаяр ахлагчтай баг амжилттай оролцлоо.

